



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 06/1669 тоот албан бичгийн дагуу албаны хэрэгцээнд олон үйлдэлт өнгөт хувилагч машиныг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны А/06, А/15, А/17, А/28 дугаар тушаалаар тус тус батлагдсан хөрөнгө оруулалт болон урсгал засварын ажлуудын тендерийн баримт бичгийн орлогоор худалдан авахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/ -д үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах 9,950,000.00 /есөн сая есөн зуун тавин мянга/ төгрөгийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны А/06, А/15, А/17, А/28 дугаар тушаалаар тус тус батлагдсан хөрөнгө оруулалт болон урсгал засварын ажлуудын тендерийн баримт бичгийн орлогоос санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Д.Булган/-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэлжүүлж холбогдох эд хариуцагчид хүлээлгэн өгөхийг байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөлд үүрэг болгосугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА

Б.БАДРАЛ

УХА0501 9077367